



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо 2024.04.29

Дугаар 01/24

Улаанбаатар хот

Хурал хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Компанийн дүрмийн 7.4 дэх заалт, Хувьцаа Эзэмшигчдийн 31-р хурлын тооллогын комиссын 01 дугаар тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Баянгол Зочид Буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 31-р хуралд саналын эрхтэй 381,133 ш хувьцааг эзэмшсэн 1058 хувь нийлүүлэгчдээс 333,222 хувьцаа эзэмшдэг хувь нийлүүлэгч саналаа ирүүлсэн нь нийт хувьцааны 87.43 хувь болсон тул хурлыг хүчин төгөлдөрт тооцон хуралдуулсугай.

ХУРЛЫН ДАРГА

.....Б.АЮУШ





“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо 2024.04.29

Дугаар 02/24

Улаанбаатар хот

ДҮГНЭЛТ, ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дахь заалт, Хувьцаа Эзэмшигчдийн 31-р хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн ТУЗ-ын зардлын төсвийг хавсралтаар баталсугай.



[Handwritten signature]

Б.АЮУШ



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо 2024.04.29

Дугаар 03/24

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дахь заалт, Хувьцаа Эзэмшигчдийн 31-р хурлын тооллогын комиссын 03 дугаар тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр дараах нэр бүхий 5 хүнийг сонгосугай.

1/ Х.Баттуул

2/ М.Золжаргал

3/ Б.Намуун

4/ Х.Цэндбаяр

5/ З.Цэрэнчимэг

2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр дараах нэр бүхий 4 хүнийг сонгосугай.

1/ Б.Аюуш

2/ Б.Саруул

3/ С.Энхтуул

4/ Ц.Эрдэнэбат

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрэм холбогдох дотоод журмаар тогтоосон бүрэн эрхээ зохих ёсоор хэрэгжүүлж компанийн эрх ашгийн төлөө мэдлэг чадвараа дайчлан ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.



[Signature]
ХУРЛЫН ДАРГА Б.АЮУШ

**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН
КОМИССЫН ТОГТООЛ**

Огноо 2024.04.29

Дугаар 01/24.

Улаанбаатар хот

Хурал хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.4 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналын хуудас бүртгэсэн дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

“Баянгол Зочид Буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 31-р хуралд саналын эрхтэй 381,133 ш хувьцааг эзэмшсэн 1058 хувь нийлүүлэгчдээс 333,222 ширхэг хувьцаа эзэмшсэн хувь нийлүүлэгчид саналаа ирүүлсэн нь нийт саналын эрхтэй хувьцааны 87,43 хувийг төлөөлж байгаа тул хурал хүчин төгөлдөрт тооцон хуралдуулсугай.

КОМИССЫН ДАРГА..... Д.САМДАНЖАМЦ



**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН
КОМИССЫН ТОГТООЛ**

Огноо 2024.04.29

Дугаар 02

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дахь заалт, 63 дугаар зүйлийн 63.5 дахь заалт болон 67 дугаар зүйлийн 3.8 дахь заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлаар нийт өгсөн саналын тоо 333,222 үүнээс татгалзсан 0 түдгэлзсэн 0 хүчингүй 29, зөвшөөрсөн 33,193 санал өгсөн нь нийт саналын 99,99 хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон.
2. Компанийн ТУЗ-ын 2023 оны зардлын төсвийг батлах асуудлаар нийт өгсөн саналын тоо 333,222 үүнээс татгалзсан 0, түдгэлзсэн 0, хүчингүй 29, зөвшөөрсөн 33,193 санал өгсөн нь нийт ирүүлсэн саналын 99,99 хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсныг мэдэгдсүгэй.

КОМИССЫН ДАРГА..... Д.САМДАНЖАМЦ



**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН
КОМИССЫН ТОГТООЛ**

Огноо 2024.04.29

Дугаар 03

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон
дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дах заалт, 72 дугаар зүйл, санал хураах хуудсыг тоолсон дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

ТУЗ-ийн Ердийн гишүүнд нэр дэвшигчдийн авсан саналын тоо:

1. Х.Баттуул	333,193 санал буюу 99,99 хувь
2. Б.Намуун	333,193 санал буюу 99,99 хувь
3. М.Золжаргал	333,193 санал буюу 99,99 хувь
4. Х.Цэндбаяр	333,193 санал буюу 99,99 хувь
5. З.Цэрэнчимэг	333,193 санал буюу 99,99 хувь

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн авсан саналын тоо:

1. Б.Аюуш	333,193 санал буюу 99,99 хувь
2. Б.Саруул	333,193 санал буюу 99,99 хувь
3. С.Энхтуул	333,193 санал буюу 99,99 хувь
4. Ц.Эрдэнэбат	333,193 санал буюу 99,99 хувь

тус тус санал авсан тул ТУЗ-ийн гишүүдээр сонгогдсоныг мэдэгдсүгэй.

КОМИССЫН ДАРГА..... Д.САМДАНЖАМЦ

